**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/20/НА/-СТА-ТШЗ**

---

Цахим хуудас: www.audit.mn

Ховд хот

2022 он


Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Ахлах аудитор: Л.Галбадрах

Утас: 70432545

цахим хаяг: galbadrah.L@audit.gov.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....................3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....................3
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....................4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....................5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....................6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....................7
3. Аудитын тайлан....................8
3.1 Ерөнхий зүйл ....................8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................9
3.4 Материаллаг байдал ....................9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....................9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....................10
3.8 Аудитын гол асуудал ....................10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....................11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....................11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................11
4. Аудитын илрүүлэлт ....................11
4.1 Залруулсан алдаа....................11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................12


| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| НА | Нотлох ажил |

ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

2022.02.14 № 2/28
танай __________ -ны № __________ -т

ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДЭРГЭДЭХ
СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА Л.АРИУНАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Х.БОЛДБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **687058.0** | **501575.7** |
| **33** | **АВЛАГА** | 453058.0 | 1575.7 |
| **335** | **Бусад авлага** | 453058.0 | 1575.7 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 453058.0 | 1575.7 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 234000.0 | 500000.0 |
| **354** | **Хангамжийн материал** | 234000.0 | 500000.0 |
| 35420 | Аж ахуйн материал | 234000.0 | 0.0 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **67026445.2** | **60264735.1** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 67026445.2 | 60264735.1 |
| **392** | **Биет хөрөнгө** | 67026445.2 | 60264735.1 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 42900000.0 | 42900000.0 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -446875.0 | -7596875.0 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 56493225.0 | 64325125.0 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -33053337.8 | -40086095.7 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 9197357.0 | 9115757.0 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -8063924.0 | -8393176.2 |
| 39301 | Програм хангамж | 450000.0 | 450000.0 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -450000.0 | -450000.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **67713503.2** | **60766310.8** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **67713503.2** | **60766310.8** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 67713503.2 | 60766310.8 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 67713503.2 | 60766310.8 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 67713503.2 | 67713503.2 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **67713503.2** | **60766310.8** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **259058724.0** | **209428546.0** |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **259058724.0** | **201242046.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 259058724.0 | 96944200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 259058724.0 | 96944200.0 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **218550622.5** | **216375738.4** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **218550622.5** | **216375738.4** |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 218450622.5 | 215492572.1 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 37778452.0 | 82168273.0 |
| 210101 | Үндсэн цалин | 25170074.0 | 54544723.7 |
| 210102 | Нэмэгдэл | 7727093.0 | 20953556.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 2643818.0 | 4228997.4 |
| 210104 | Урамшуулал | 2237467.0 | 2440995.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 4687362.0 | 12124113.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3187639.0 | 8772303.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 374922.0 | 870430.2 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 299947.0 | 656738.4 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 74989.0 | 170290.9 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 749865.0 | 1654349.7 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 607440.0 | 2028794.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 40000.0 | 618794.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 182500.0 | 718200.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 290440.0 | 492400.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 94500.0 | 199400.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 174752570.6 | 103356034.9 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 174536570.6 | 102520534.9 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 216000.0 | 698000.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 624797.9 | 15815357.1 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 45000.0 | 330247.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 579797.9 | 14675110.1 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 100000.0 | 883166.4 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 100000.0 | 244000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 100000.0 | 244000.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **40508101.5** | **-6947192.4** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **40508101.5** | **-6947192.4** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 00.0 | 00.0 | 1,480,443.0 | 1,480,443.0 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.0** | **00.0** | **1,480,443.0** | 1,480,443.0 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.0 | 40,508,101.5 | 40,508,101.5 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.0** | **00.0** | **67,713,503.2** | 67,713,503.2 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.0** | **00.0** | **67,713,503.2** | 67,713,503.2 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **00.0** | **00.0** | **67,713,503.2** | 67,713,503.2 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.0 | 00.0 | -6,947,192.4 | -6,947,192.4 |
| D09 | **2021оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **00.0** | **00.0** | **60,766,310.8** | 60,766,310.8 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **353947799.0** | **201242046.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **353947799.0** | **201242046.0** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 353947799.0 | 96944200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 353947799.0 | 96944200.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 0.0 | 104297846.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 4676400.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.0 | 99621446.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **350438099.0** | **201242046.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **350438099.0** | **201242046.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **350043099.0** | **200358879.6** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 86648950.0 | 82159275.5 |
| 210101 | Үндсэн цалин | 57716500.0 | 54544723.6 |
| 210102 | Нэмэгдэл | 19178300.0 | 20953556.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4579200.0 | 4220000.0 |
| 210104 | Урамшуулал | 5174950.0 | 2440995.3 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11613500.0 | 10632779.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 8172400.0 | 7380968.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 860300.0 | 826125.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 688200.0 | 660900.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 172100.0 | 160435.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1720500.0 | 1604349.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2469800.0 | 2249300.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 541400.0 | 563800.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 845000.0 | 718200.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 619400.0 | 513300.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 464000.0 | 454000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 490300.0 | 0.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 490300.0 | 0.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 248444449.0 | 103986424.8 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 247457949.0 | 103129424.8 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 99000.0 | 49500.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 88000.0 | 88000.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 799500.0 | 719500.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 376100.0 | 1331100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 0.0 | 1000000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 376100.0 | 331100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **395000.0** | **883166.4** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 305000.0 | 244000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 305000.0 | 244000.0 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 90000.0 | 0.0 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90000.0 | 0.0 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 0.0 | 639166.4 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.0 | 639166.4 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **3509700.0** | **0.0** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **3509700.0** | **0.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3509700.0** | **0.0** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3509700.0 | 0.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-3509700.0** | **0.0** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 0.0 | 0.0 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 0.0 | 0.0 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 96944100.0 | 96305054.8 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 96944100.0 | 96305054.8 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 96700100.0 | 96061054.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 82018200.0 | 81818775.5 |
| 210101 | Үндсэн цалин | 57716400.0 | 54544723.6 |
| 210102 | Нэмэгдэл | 15170400.0 | 20953556.7 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4579200.0 | 4220000.0 |
| 210104 | Урамшуулал | 4552200.0 | 2100495.3 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 11072400.0 | 10632779.3 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7791700.0 | 7380968.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 820200.0 | 826125.3 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 656100.0 | 660900.3 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 164000.0 | 160435.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1640400.0 | 1604349.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2249300.0 | 2249300.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 563800.0 | 563800.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 718200.0 | 718200.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 526500.0 | 513300.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 440800.0 | 454000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1029100.0 | 1029100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 172100.0 | 172100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 49500.0 | 49500.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 88000.0 | 88000.0 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 719500.0 | 719500.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 331100.0 | 331100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 331100.0 | 331100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 244000.0 | 244000.0 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 244000.0 | 244000.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 244000.0 | 244000.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 96944200.0 | 96305054.8 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 96944200.0 | 96305054.8 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **251910599.0** | **104297824.8** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **251910599.0** | **104297824.8** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 251910599.0 | 104297824.8 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | | 340500.0 |
| 210104 | Урамшуулал | 622750.0 | 340500.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4000000.0 | 0.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4000000.0 | 0.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 247242849.0 | 102957324.8 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 247242849.0 | 102957324.8 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45000.0 | 1000000.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 1000000.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 45000.0 | 0.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 251910599.0 | 104297846.0 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 251910599.0 | 104297846.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 45020.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 104252826.0 |

# 3. Аудитын тайлан

## 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалтын талаарх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор Л.Галбадрах 2022 оны 02 дугээр сарын 07-нээс 2022 оны 02 дугаар сарын 14–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 5-ний өдрийн 13 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

## 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтэс “Монгол Улсын статистикийн мэдээллийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр эрхлэн гаргаж, хэрэглэгчдэд адил тэгш үйлчлэхэд оршино.” гэсэн зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

Монгол улсын үндсэн хууль, Статистикийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хуулийг баримталж, орон нутаг, салбар, байгууллагын онцлогийг үл харгалзан хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг хангах, мэдээллийг үнэн бодитой,шуурхай мэдээлэх ,шинжлэх ухааны үндэслэлтэй , ил тод нээлттэй байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зарлагын 216.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцон 2.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 1.6 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 0.5 сая төгрөг болж 0.2 сая төгрөгөөр буюу хангамжийн материалын үлдэгдлээр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 7.9 сая төгрөгийн үнэ төлбөргүйгээр, 29.0 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 29.1 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 0.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 109.0 сая төгрөг, оны эцэст 60.2 сая төгрөг болж 48.7 сая төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардалтай холбоотой байна.

Тайлант онд 7.9 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, тайлант оны эцэст 60.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Тайлант оны эцэст 1527 мянган төгрөгийн авлагын үлдэгдэл нь хувь хүний орлогын албан татвартай холбоотой үүссэн авлага байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 67.7 сая төгрөг байсан оны эцэст 60.7 сая төгрөг болж тайлант онд 6.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 6.9 сая төгрөг болсон байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын дэргэдэх Статистикийн хэлтэс 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 201,2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 201.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 201.2 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 201.2 сая төгрөгийн төсөв баталж улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 0.6 сая төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллыг 0.1 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийг 0.4 сая төгрөгөөр хэмнэж, зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансаар 104.2 сая төгрөгийг орж ирснийг бусдаар гүйцэтгүүлэх нийтлэг ажил үйлчилгээний зардалд тусган зарцуулсан байна.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 150 мэдээллээс 150 мэдээллийг хугацаандаа оруулсан байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 12 ажил гүйлгээг шилэн дансны сайтад байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн "6.1.4.жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор" гэсэн заалтыг хэрэгжүүлэн хагас жилийн санхүүгийн тайланг шилэн дансны сайтад байршуулсан байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй, и баримт бүрдүүлэлтийг цаашид сайжруулах, үндсэн хөрөнгийг ангиллыг зөв бүртгэх,шатахууны тооцооны хуудасны хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн байна. Өгсөн зөвлөмжийг тайланд онд хэрэгжүүлэн ажилласан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын нэмэлт дансаар Үндэсний статистикийн хорооноос 104.2 сая төгрөг хөрөнгө оруулалт хийгдэж судалгааны ажил хэрэгжүүлж байгаа гэрээт албан хаагчдын цалин, судалгааны зардлыг нэмэлт дансаар дамжуулан зарцуулж байгаа асуудлыг улсын хэмжээнд нэгтгэн үзэх шаардлагатай байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 0.1 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

- Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаа илээргүй болно.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 4.2 Зөвлөмж

***1. Сэлбэг хэрэгслийн зарцуулалттай холбоотой асуудал:***

Илрүүлэлт: Ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгахдаа өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй. 0.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн.

*Өгсөн зөвлөмж*: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-заалт "Эзэмшилдээ байгаа илүүдэл буюу ашиглах хугацаа дууссан, шаардлага хангахгүй болсон эд хөрөнгийг худалдах, шилжүүлэх, устгах' 31.3.1' худалдах, шилжүүлэх,

устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх; гэсэн заалтуудыг өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаж хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дугээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Статистикийн хэлтэс | 0 | 0 | | | | | 0 | 0 | 1 | 0.1 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АХЛАХ АУДИТОР: Л.Галбадрах**